

Петро Матад Лимитед (“Петро Матад” буюу “Компани”)

Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас “Петро Матад” компанид хөрөнгө оруулахаар боллоо

Лондонгийн хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээл (AIM)-д бүртгэлтэй, Монгол Улсад газрын тосны хайгуулын үйл ажиллагаа, цаашид газрын тос олборлолт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани болох “Петро Матад” компани Европын сэргээн босголт хөгжлийн банкны (“ЕСБХБ”) захиалгаар нэг бүр нь 0,01 ам.долларын үнэтэй энгийн хувьцааг (“шинээр гаргасан хувьцаа”) шинээр гарган 6 сая ам.долларын хөрөнгө босгож байгааг мэдэгдэхэд таатай байна. Шинээр гаргах хувьцааны захиалгын үнэ нэг бүр нь 14 пенс байх бөгөөд компанийн одоогийн энгийн хувьцааныхтай ижил нөхцөлтэй байна.

Шинээр хувьцаа гаргахдаа хоёр хэсэгтэй гаргах бөгөөд түүний эхний хэсгийг (“хувьцааны эхний хэсэг”) ирэх долоо хоногуудад шууд хөрөнгө оруулалтын гэрээний урьдчилсан нөхцөлийг биелүүлснээр, цаашид тохиролцох тодорхой нөхцөлүүдийг биелүүлэх буюу хамгийн чухал нь ЕСБХБ-ны төлөөлөгчийг “Петро Матад” компанийн захирлуудын зөвлөлд томилсноор хоёр дахь хэсгийг гаргана . Хувьцаа гаргасны дараа шинээр гаргах хувьцааны хэсэг тус бүрийг AIM захад бүртгүүлэх өргөдөл гаргах юм.

“Петро Матад” компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Дуглас Макгей хувьцааны захиалгын талаар хэлэхдээ:

“Манай компанид хөрөнгө оруулалт хийх замаар Монгол Улсын газрын тосны хайгуулын салбарт дэмжлэг үзүүлж буй ЕСБХБ-ийг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн ЕСБХБ-наас “Петро Матад” компанид ийнхүү дэмжлэг үзүүлж байгаа нь Монгол Улсын хурдацтай хөгжиж байгаа хувийн хэвшлийн салбарын хувьд чухал ач холбогдолтой үйл явдал юм. Мөн тус компанийн хамгийн том хувьцаа эзэмшигч болох “Петровис” ХХК-ийг энэхүү үйл явцад дэмжлэг үзүүлж олон улсын бизнесийн зарчимийг дэмжигч гэдгээ харуулсныг бад бид онцгойлон дурьдах ёстой.

Энэ үйл явдал нь үндсэндээ манай компанийг хөгжин дэвжиж байгааг харуулсан үнэн бодит баримт юм. Хувьцааны хоёр дахь хэсгийг гаргаж дууссанаар ЕСБХБ нь тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 17 орчим хувийг эзэмших бөгөөд ийнхүү нэр хүндтэй хөрөнгө оруулагч “Петро Матад” компанид хувь эзэмшиж хөрөнгөө оруулж байгаа явдал тус компанийн өнөөг хүртэл гаргасан амжилтын баталгаа болж байна. ЕСБХБ нь бусад хувь нийлүүлэгчийн хамт “Петро Матад” компанийн цаашдын тогтвортой өсөлт хөгжлийг хангах болно. Түүнчлэн ЕСБХБ-ийг өөрийн туршлага хийгээд захирлуудын зөвлөлийн түвшинд хувь нэмрээ оруулна гэдэгт бид гүнээ итгэн найдаж байна.

Манай компани хээрийн ажил түр зогссон өвлийн улиралд Монгол Улсын төвийн бүсэд орших IV, V дугаар талбайн шинээр байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд судалгаа явуулж түүнийг хэрэгжүүлэхэд бэлтгэх, ХХ талбайн өрөмдлөгийн хөтөлбөрийг үргэлжлүүлэхээр инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэж холбогдох бэлтгэл ажил хийж байна” гэлээ.

ЕСБХБ-ны Байгалийн нөөц баялаг хариуцсан захирал Кевин Борц: “ЕСБХБ дотоодын хувийн компанийн Монгол Улсад анх удаа хэрэгжүүлж буй газрын тосны хайгуулын

төсөлд дэмжлэг үзүүлж байгаадаа баяртай байна. Энэхүү үйл явц Монгол Улсын эдийн засагт хувийн хэвшлийн салбарын гүйцэтгэх үүргийг бэхжүүлж хайгуулын төсөл амжилттай хэрэгжсэн тохиолдолд хангамжийн шинэ эх үүсвэр бий болгосноор эцсийн дүндээ эрчим хүчний хувьд гадаадын ханган нийлүүлэгчдээс хараат байдлыг багасгахад тус дөхөм болно. Түүнчлэн уг төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны болон байгууллагын зохистой удирдлагын стандартыг шинээр нэвтрүүлж улам боловсронгуй болгох юм” гэж хэлэв.

Хувьцаа гаргасны үр дүнд олох орлогын ашиглалт

Компани хувьцаа гаргасны үр дүнд олох цэвэр орлогыг өөрийн өрөмдлөгийн хөтөлбөр болон XX, IV, V талбайн цаашдын хайгуулын ажилд ашиглана.

Редакторт:

"Петро Матад" компанийн тухай

“Петро Матад” компани Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид газрын тос олборлож үйлдвэрлэл явуулахад чиглэгдсэн группын толгой компани юм. Тус групп Монгол Улсын Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах тухай гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Үндсэн хөрөнгө нь тус улсын алс дорнодод орших 14250 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны XX талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээ юм. Үлдсэн хоёр нь болох IV, V талбай Монгол Улсын төв хэсэгт орших бөгөөд хамтдаа нийт 73498 хавтгай дөрвөлжин километр талбайг эзэлнэ.

“Петро Матад Лимитед” компани Кэймэн аралд 1483V тоот компанийн дугаарт бүртгэгдсэн. Компанийн хаяг нь IM1 1EQ, Кэймэн арал, Дуглас хот, Проспект Хилл, Виктори Хаус.

ЕСБХБ-ны тухай

ЕСБХБ нь Төв Европоос Төв Ази хүртэлх 29 улсад хэрэгжиж буй төслүүдэд дэмжлэг үзүүлдэг олон улсын санхүүгийн байгууллага юм. ЕСБХБ тус бүс нутгийн цорын ганц хамгийн том хөрөнгө оруулагч бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулж буй улс орнуудад ихээхэн хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт татдаг. 61 улс, засгийн газар хоорондын хоёр байгууллагаас бүрдсэн ЕСБХБ зорилгоо хэрэгжүүлэх үүднээс засгийн газар, эрх бүхий байгууллага, иргэний нийгмийн төлөөлөгчидтэй улс төрийн яриа хэлэлцээ хийж нягт хамтран ажилладаг. ЕСБХБ өөрийн бүхий л үйл ажиллагаанд байгууллагын зохистой удирдлага, тогтвортой хөгжлийн стандартыг дээд зэргээр баримталж ажилладаг. www.ebrd.com

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараахь хаягаар холбоо барина уу.

“Петро Матад Лимитед” компани
Гүйцэтгэх захирал Дуглас Ж.Макгэй +976 11 331099

“Хансон Уэстхаус Секьюритис Лимитед” компани
Ричард Бэти, Питр Нортон +44 (0)20 7601 6100

“Бэнксайд Консалтантс” компани
Саймон Роччилд, Оливер Уинтерс, Луиз Мэсон +44 (0)20 7367 8888

Тус компанийн зөвлөх “Хансон Уэстхаус Лимитед” компани 2009 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн “Уэстхаус Секьюритис Лимитед” болж нэрээ өөрчилсөн.